

ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Гадаад зах зээл

2023.09.04





ОНЦЛОХ МЭДЭЭ :

АНУ-н хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл

Өнгөрсөн 7 хоногийн ажлын байрны мэдээнээс онцлох зүйлс:

- Шинээр зарлагдаж буй ажлын байрны тоо болон ажлаас гарсан хүмүүсийн тоо буурч байна.
- ADP хувийн байгууллагуудын ажлын байр цалингийн түвшинтэй хамт буурч байна.
- Ажилгүйдлийн түвшин өсөж эхэллээ.

Удааширч буй хөдөлмөрийн зах зээлээс ажиглагдсан 3 зүйлс:

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-аас гардаг хөдөлмөрийн зах зээлийн талаарх хэд хэдэн мэдээллүүд бүгд нэг зүйлийг илэрхийлж байв. Тэр нь цар тахлаас хойш асар их өсөлттэй байсан ажлын байрны нөхцөл байдал эргээд буурч байгаатай холбоотой байлаа.
- Шинжээчид хөдөлмөрийн зах зээлийн удаашралыг дараах 2 үр дагавартай байж болзошгүй гэж харж байна:
 1. ХНС бодлогын хүүг нэмэлгүй харзнана.
 2. Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны өгөөж дээд цэгтээ хүрсэн байж магадгүй тул хөдөлмөрийн зах зээлийн удаашрал нь эдийн засгийн өсөлтийг бууруулж, инфляцыг өсөхгүй байхад нөлөөлөх боломжтой юм.
- Шинжээчдийн үзэж байгаагаар хөдөлмөрийн зах зээл удаашрах нь хөрөнгийн зах зээлд сайнаар нөлөөлөх ба ХНС-ийн бодлогын хүүгийн өсөлтийг зогсооно гэж харж байна. 9 сард зах хэлбэлзэлтэй тулгардаг түүхтэй ч үйлчилгээний инфляц буурч байгаа, ХНС бодлогын хүүгээ өсгөхөө зогсоох зэрэг нь хувьцаа болоод бондын ханшийг өсөхөд нөлөөлж болох юм.

1. Шинээр зарлагдаж буй ажлын байрны тоо болон ажлаас гарсан хүмүүсийн тоо буурч байна.

- Хөдөлмөрийн зах зээлийг урьдчилан харуулдаг 2 дохио нь шинээр зарлагдсан ажлын байрны тоо (ШЗАБТ) ба ажлаасаа гарсан хүмүүсийн тоо байдаг. Өнгөрсөн 7 хоногийн мэдээгээр ШЗАБТ 9.6 саяас 8.8 сая болж буурсан нь таамаглаж байсан 9.5 саяас бага байсан юм. Энэ нь 2021 оны 3 сараас хойших хамгийн доод түвшин аж.
- Ажлын байр болон ажлаасаа гарч байгаа хүмүүсийн тоо буурч байгаа нь хөдөлмөрийн зах зээлийг удааширч байгааг илтгэдэг. Хэрвээ ажилчид шинэ ажил олно гэдэгт итгэлгүй байвал хуучин ажлаасаа гарч зүрхэлдэггүй. Илүү өргөн хүрээгээр харвал, өрхийн хэрэглээний түвшин хөдөлмөрийн зах зээл хэр өөдрөг байгаагаас шалтгаалдаг. Иймд, хөдөлмөрийн зах зээл буурч байгаа нь өрхийн хэрэглээг цаашид буурахад хүргэж магадгүй юм.

Ажлын байрны нээлт ба хөдөлмөрийн эргэлтийн судалгаа



2. ADP хувийн байгууллагуудын ажлын байр цалингийн түвшинтэй хамт буурч байна.

- 8 сарын ADP мэдээ таамаглаж байснаас доогуур байсан. Нийт нэмэгдсэн ажлын байрны тоо 177 мянга байсан нь өнгөрсөн сарын 324 мянгаас эрс буурсан ба таамаглаж байсан 194 мянгаас бага байлаа. ADP мэдээнд дурдсанаар: “Энэ сарын ажлын байрны тоо цар тахлын өмнөх хэмжээнд хүрсэн. 2 жил хүчтэй сэргэсэн энэ өсөлт одоо илүү тогтвортой хэмжээнд хүрлээ” гэв.
- Мэдээнээс нэмж онцлох нэг зүйл нь цалингийн өсөлт байв. Цалин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9% өссөн нь 2021 оны 10 сараас хойших хамгийн бага үзүүлэлт байв. Цалингийн өсөлт нь ХНС-ийн инфляцыг хэмжих гол үзүүлэлтүүдийн нэг байдаг тул энэ удаагийн хурлаар бодлогын хүүг өсгөхгүй байх магадлал нэмэгдсэн.



- Гэвч, Edward Jones-ийн шинжээчдийн үзэж буйгаар өнгөрсөн 7 хоногийн бодлогын хүүгийн өсөлт эцсийн байх боломжтой гэв. ХНС сүүлийн жил хагасын хугацаанд бодлогын хүүг 5%-иас дээш хүргэсэн ба одоо түр зогсож инфляц болоод эдийн засагт хэр нөлөөлж байгааг ажиглах байх. Инфляцыг урьдчилан харуулдаг үйлдвэрлэл, үйлчилгээний ISM үнэ сүүлийн үед буурсаар байгаа ба орон сууцны худалдах үнэ, түрээсийн үнэ бүгд буурсаар байгаа.
- ХНС бодлогын хүүг өсгөхөө зогсоож магадгүй ч ирэх жилээс наана буулгахгүй л болов уу. Хэрвээ инфляцын түвшин 2%-д хүрэх юм бол ХНС ирэх жилийн эхээр бодлогын хүүг зөөлрүүлж магадгүй. Иймд, шинжээчид бодлогын хүүг 2024 оны эхэн хүртэл буухгүй гэж үзэж байна.


3. Ажилгүйдлийн түвшин өсөж эхэллээ

- Ажилгүйдлийн түвшин 3.5%-иас 3.8% болж өссөн. Дундаж 1 цагийн цалингийн түвшин өнгөрсөн жилийн мөн үеэс 4.3%-иар өссөн нь таамаглаж байсан 4.4%-иас бага байв. ХНС энэ тоог 4%-иас доош орсноор инфляц 2%-д хүрнэ гэж харж байгаа. Цалингийн өсөлт 4.3%-иар өссөн нь инфляц (3.2%)-аас илүү байгаа нь өрхийн эдийн засагт одоогоор эергээр нөлөөлж байна.

ХНС болон хөрөнгийн зах зээлд эдгээр нь хэрхэн нөлөөлөх?

- Хөдөлмөрийн зах зээл удааширч байгаа нь ХНС бодлогын хүүг өсгөхүй байхад хүргэнэ. ХНС бодлогын хүүг өсгөсөн гол шалтгаануудын нэг нь цалингийн өсөлтийг буулгахад чиглэж байсан.
- ХНС-ийн 6 сард хийсэн төсөөллөөр ажилгүйдлийн түвшин 4.5%-д хүрнээр хөдөлмөрийн зах зээл илүү хэвийн түвшинд очно гэсэн. Шинжээчид энэ удаагийн мөнгөний бодлогын хурлаар ХНС бодлогын хүүг өсгөхгүй гэж харж байна. Одоогоор төв банкны бодлогын хүүг 2024 оны 5 сараас нааш бууруулахгүй гэж харж байна. ХНС инфляцыг 2% хүртэл буухаас нааш бодлогын хүүг бууруулахгүй болов уу.

АНУ-ын ажиллах хүчний оролцоо өндөр хэвээр байна (%)



Хөдөлмөрийн зах зээлийн удаашрал нь ЗГҮЦ-ны зах зээлд шууд нөлөөлнө.

- Өнгөрсөн 7 хоногт ЗГҮЦ-ны өгөөж дээд цэгээсээ буурсан. Өгөөж ингэж буурч байгаа нь бонд, хөрөнгийн зах зээлийг өсөхөд хүргэсэн. S&P 500 хэдийгээр 8 сард 2% унасан боловч энэ жил 17% өссөн үзүүлэлттэй байна. 9, 10 сар нь хөрөнгийн зах зээлд ээлгүй байдаг боловч хөдөлмөрийн зах зээлээс гарсан мэдээ нь захыг өсөхөд нөлөөлж болох юм.

САНАМЖ

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!